

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 13-ний өдрийн 4 дугаар
тушаалын 13 дугаар хавсралт 104

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам
3. Орон тоо, албан тушаал: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Санхүүгийн шинжээч	
4. Ажлын байрны шууд харьяалах удирдах албан тушаалын нэр: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Төслийн зохицуулагч, Сангийн удирдлага хариуцсан дэд зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны үндсэн зорилго:	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүх үйл ажиллагааг холбогдох санхүүгийн болон зохицуулалтын хүрээнд нийцүүлэн хэрэгжүүлэх, гэрээ боловсруулах, маргаан шийдвэрлэх, хэлэлцээр байгуулах үйл явцад санхүүгийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн Хөгжлийн түнш байгууллагуудын дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн тайлагнал хийх, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн нэгдсэн тайланг нэгтгэн гаргах.	
2. Ажлын байрны зорилтууд:	БНХХААБС-ийн санхүүгийн баримт бичиг боловсруулалт, санхүүжилтийн механизм, хууль-журмын нийцүүлэлт, цахим тайлагналын систем хөгжүүлэлт, төсөв-зардлын тооцоолол, Хөгжлийн түншийн санхүүгийн шаардлагын хэрэгжилт, чадавх бэхжүүлэх сургалт болон дотоод удирдлага-мэдээллийн системийн сайжруулалтыг хариуцах.	
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хугацаа/ хуваарь	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1. БНХХААБС-ийн санхүүгийн удирдлагатай холбоотой асуудлуудын талаар төслийн хэрэгжилтийн баримт бичгийн боловсруулалт, сайжруулалтад холбогдох оролцоог хангах; 2. БНХХААБС-ийн зээлийн дэд сангуудын хувьд тохиромжтой санхүүжилт, зарцуулалтын механизмыг боловсруулах, Сангийн менежерийн чадавхыг төслийн хөгжлийн үр дүнд хүрэхэд чиглэн сайжруулах зөвлөгөө, чиглэл өгөх, дотоод	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны явцын тайлан, сар, улирал, жилийн тайлан

хяналт ба бүртгэлийн тогтолцооны үр нөлөөг хянах; 3. Монгол Улсын “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”, Сангийн яам , Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага, мөн Азийн Хөгжлийн Банк, Уур амьсгалын ногоон сан болон холбогдох бусад Хөгжлийн түншүүдийн хүрээнд тохиролцсон санхүү, засаглалын нөхцөл шаардлагуудыг ханган ажиллах үүднээс БНХХААБС-ийн байгуулалт, удирдлагын үйл ажиллагаанд Сангийн менежерт дэмжлэг үзүүлэх; 4. Сангийн менежерт төслийн бүртгэл, тайлан, жилийн төсөв, IFRS-д нийцсэн аудитлагдсан санхүүгийн тайланг Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, АХБ, Сангийн яаманд хүргүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим санхүүгийн бүртгэл, тайлагналын системийг боловсруулах, хэрэгжүүлэх; 5. Төсвийн болон санхүүгийн мэдээллийн системийг сайжруулах, санхүүгийн менежментийн гарын авлага, журмууд боловсруулах чиглэлд БНХХААБС-ийн ажилтнуудад шууд туслалцаа үзүүлэх; 6. ХХН-д төсвийн тооцоолол, зардлын хуваарилалт, зээлийн хөрөнгийн зарцуулалт, гэрээний төлөвлөгөө, санхүүжилтийн муруй (S-curve) бэлтгэхэд туслалт; 7. Хөгжлийн түншүүдийн санхүүжилт, зарцуулалтын журам, гарын авлагын дагуу нягтлан бодох бүртгэл, санхүүгийн менежмент, тайлагналын тогтолцоог бүрдүүлэх, сайжруулах талаар Сангийн менежер болон ажилтнуудад зөвлөгөө, сургалт өгөх; 8. Сангийн менежер болон ажилтнуудад санхүүгийн загварчлал, хөрөнгийн үнэлгээ, корпорац ба төслийн санхүүжилт, бусад банк, хөрөнгө оруулалтын гол ур чадваруудын чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах; 9. БНХХААБС-ийн дотоод удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлэх, үнэлгээний болон арын оффисын үйл ажиллагааг сайжруулах. 10.Төслийн зардал, төлөвлөлтөд идэвхтэй хяналт тавьж, Бүсийн агро-бизнесийн ногоон, хүртээмжтэй сангийн үйл		
--	--	--

ажиллагаатай холбоотой зээлийн хэмнэлт, дутагдал, хэрэгжилтийг хангах; 11.Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчаас өгсөн Бүсийн агро-бизнесийн ногоон, хүртээмжтэй сантай болон төсөлтэй холбоотой бусад үйл ажиллагааг гүйцэтгэх.		
---	--	--

Тайлбар: Ажил гүйцэтгэх хугацаа, хуваарийг жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тодорхойлно.

В. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

		Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Боловсрол	Нягтлан бодох бүртгэл, санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх (магистрын зэрэгтэй бол давуу тал болно);	
		Мэргэжил	Мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жилийн туршлагатай, үүнээс дор хаяж 5 жил нь олон улсын санхүүгийн байгууллагын төслийн санхүүгийн менежмент, удирдлагад ажилласан туршлагатай байх.	
		Туршлага	Аудит, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дор хаяж 5 жилийн туршлагатай, удирдах түвшний үүрэг хариуцлага гүйцэтгэж байсан бол давуу талтай.	Санхүүгийн загварчлал, хөрөнгийн үнэлгээ, корпорац ба төслийн санхүүжилт, банк, хөрөнгө оруулалтын үндсэн ур чадваруудыг бүрэн эзэмшсэн байх.
		Ур чадвар	Англи хэлний яриа болон бичгийн өндөр түвшний чадвартай байх.	

	1.2.Тусгай шаардлага	1. АХБ болон бусад олон улсын байгууллагын үйл ажиллагаа, захиргааны болон санхүүжилт, зарцуулалтын бодлого, журамтай сайн танил байх; 2. IFRS, MOF, FRC-ийн шаардлага, АХБ болон бусад олон улсын байгууллагуудын бодлого, удирдамжийн дагуу төслийн санхүүгийн тайланг бэлтгэх чадвартай байх; 3. IFRS болон төслийн санхүүгийн бүртгэл, хяналт, тайлагналын аргачлалыг мэддэг байх 4. Харилцааны болон багаар ажиллах өндөр чадвартай байх;
--	----------------------	---

Г. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ	
Шийдвэрийн огноо:	2026.01.13
Дугаар:	A/04
(тамга/ тэмдэг)	
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	(И.БАТХҮҮ)
2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр	

